



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянбулаг сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/14/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)

Аудитор: Д.Цэцэгмаа

Утас: ..... Цахим хаяг: .....

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

᠋᠋᠋᠋ ᠐1.27 № 1/14  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
О.ГАНДИЙМАА ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон

C:\Users\audit\_bhr3\Downloads\Аудитын гэрчилгээ (1) (3).docx

2519385

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Баянбулаг сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЭМТ-ийн эрхлэгч О.Гандиймаа -д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянбулаг сумын ЭМТ-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянбулаг сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.14-өөс 2020.01.17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.01.23-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Д.Цэцэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төв нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.10-ны өдрийн 122 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төв нь “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг чанартай үзүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянбулаг сумын ЭМТ-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянбулаг сумын ЭМТ-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Тус байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлж, мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төв нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох группийн "Acoulos" програм хангамж" ашигладаг байна.

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 35 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 27 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардлын дүнгийн 2.0* хувиар сонгов.

*Нийт зардлыг* материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд нийт зардлын дүнг сонгосон тул гүйцэтгэлийн шатанд суурь үзүүлэлтийг өөрчлөөгүй болно.

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны Үр дүнгийн тайлангийн *нийт зардал* 423282,5 мянган төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 8,486.09 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2.0 хувиар тооцсон нь төлөвлөлтийн шатанд сонгосонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 29 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 27 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	(мянган төгрөгөөр)	
			Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	441,3	
3	Албан шаардлага өгсөн	1	523,9	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
Дүн		2	965,2	

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### 2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Цалингийн тооцооллыг анхан шатны баримтаас түүн давтан тооцоолж НДШ, ХХОАТ-ыг НДШ-ийн тайлантай үлдэгдлийг тулган баталгаажуулахад ХХОАТ-ын өмнөх оны илүү төлөлтийн 441,3 мянган төгрөгийг баланст тусгаагүй байсныг суутган тооцоогүй, авлагаар тусгаагүй байсан тул төлбөрийн акт тогтоов.

Энэ нь Оршин байх, Иж бүрэн байх, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.8 “Төсвийг зүй зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:**

Төлбөрийн акт тогтоох

**2.8.1.2 Балансын данстай холбоотой асуудал**

Санхүүгийн тайланд оны эхэнд ажиллагсадтай холбогдсон 1986,1 мянган төгрөгийн, байгууллагаас авах 417,4 мянган төгрөгийн, нийт 2403,5 мянган төгрөгийн авлагатай байсан бол тайлант хугацаанд 1827,1 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, цалингийн тооцооны 576,4 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна. Үүнээс 523,9 мянган төгрөг нь өмнөх оны аудитаар ажилтанд илүү олгосон цалинг авлагаар тусгуулсан авлага боловч тухайн ажилтан ажлаас чөлөөлөгдсөн гэсэн үндэслэлээр барагдаагүй байгаа тул албан шаардлага өгөв.

Энэ нь Оршин байх, Иж бүрэн байх, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.8 “Төсвийг зүй зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:**

Албан шаардлага өгөх

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 375852,0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Тайлант хугацаанд 375852,0 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 370328,2 мянган төгрөгийг зарцуулан 5523,8 мянган төгрөгийн хэмнэлттэй гарсан. Төсөвт зардлын гүйцэтгэл 98,5%-тай байна. Төсөв хэмнэсэн шалтгаан нь ЭМД-аас санхүүжих санхүүжилтийг 2618,8 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын

шилжүүлгийн санхүүжилтийг 2899,5 мянган төгрөгөөр тус тус дутуу санхүүжилт авсантай холбоотой байна.

Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлого байхгүй байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны мэдээлэл байршуулсан байдлыг шалгахад бүтэн, хагас жил, улирал, сараар байршуулах тухайн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын 3-р улирлын мэдээлэл, тухай бүр мэдээлэх тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн 2-р сарын мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 1,2, 4 дүгээр сарын мэдээлэл, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний 1,3,4,5,6,7,8 дугаар саруудын мэдээлэл, бүтэн жилээр байршуулах аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн мэдээллүүдийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар өмнөх онд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100,0%-тай байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг Эрүүл мэндийн төвийн даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний 128 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**3 Аудит хийсэн санхүүгийн тайлан**

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>19,383,942.68</u></b>	<b><u>12,341,171.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,403,509.68	576,385.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,986,067.68	576,385.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	417,442.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	417,442.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	16,980,433.00	11,764,786.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	7,343,100.00	3,439,663.00
35110	Тусгай зориулалттай материал	7,343,100.00	3,439,663.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9,187,333.00	7,875,123.00
35410	Бичиг хэргийн материал	1,247,020.00	1,499,320.00
35420	Аж ахуйн материал	3,376,400.00	2,429,300.00
35440	Түлц, шатах тослох материал	2,672,350.00	1,662,600.00
35460	Хүнсний материал	391,810.00	589,150.00
35470	Бусад хангамжийн материал	1,499,753.00	1,694,753.00
35600	Мал амьтад	450,000.00	450,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,339,619,885.22</u></b>	<b><u>1,296,663,982.56</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,339,619,885.22	1,296,663,982.56
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,338,353,585.22	1,295,177,682.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,257,025,835.00	1,260,025,835.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,343,025.52	-45,650,649.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,827,218.00	34,806,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,877,412.04	-10,207,432.34
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	138,957,630.00	113,577,856.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-93,865,330.61	-65,684,703.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,251,410.00	20,533,929.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,622,739.61	-12,223,586.15
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,266,300.00	1,486,300.00
39301	Програм хангамж	650,000.00	870,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-650,000.00	-650,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,266,300.00	1,266,300.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b><u>1,359,003,827.90</u></b>	<b><u>1,309,005,153.56</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>335,709.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	335,709.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	335,709.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	142,177.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	159,052.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	34,480.00	00.00

Баянбулаг сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41361	Байгууллагад төлөх өглөг	34,480.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,358,668,118.90</b>	<b>1,309,005,153.56</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,358,668,118.90	1,309,005,153.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	192,097,841.00	192,097,841.00
51101	Өмч: - төрийн	192,097,841.00	192,097,841.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,096,981,003.97	1,047,318,038.63
51210	Өмнөх үеийн үр дүн	1,096,981,003.97	1,096,981,003.97
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-49,662,965.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	69,589,273.93	69,589,273.93
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,359,003,827.90</b>	<b>1,309,005,153.56</b>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлаагт оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>342,625,823.00</b>	<b>374,641,520.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,430,781.00</b>	<b>4,125,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	9,430,781.00	4,125,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,430,781.00	4,125,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,430,781.00	4,125,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>36,448,142.00</b>	<b>38,177,120.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,746,900.00	332,339,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	35,079,710.00	83,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,079,710.00	83,400.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	23,320,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	23,320,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	1,368,432.00	14,773,320.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,368,432.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	14,773,320.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>337,757,001.82</b>	<b>423,282,490.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>337,757,001.82</b>	<b>423,282,490.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	310,717,875.82	423,177,532.51
<b>2101</b>	<b>Цалин хөлө болон нэмэгдэл урамшил</b>	178,558,766.32	240,010,234.68
210101	Үндсэн цалин	178,558,766.32	239,997,734.68
210102	Нэмэгдэл	00.00	12,500.00

Баянбулаг сумын ЭМГ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,724,800.00	30,289,949.00
210201	Тэтгэврийн даатгал	17,022,980.00	23,512,049.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,184,200.00	2,259,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	818,000.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	243,270.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,456,350.00	4,518,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,447,470.00	21,275,754.00
210301	Гэрэл, цахилгаан	1,867,320.00	3,090,284.00
210302	Түлш, халаалт	12,280,150.00	17,785,450.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,630,278.00	39,045,947.00
210401	Бичиг хэрэг	1,217,884.00	6,807,820.00
210402	Тээвэр, шатахуун	18,804,300.00	21,077,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,378,982.00	1,306,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	665,700.00	95,000.00
210406	Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,563,412.00	00.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	4,155,800.00
210408	Бараа материал ахисны зардал	00.00	5,603,437.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	27,157,179.00	23,902,654.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,386,939.00	17,422,243.00
210502	Хоол, хувс	4,523,140.00	6,382,811.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,247,100.00	97,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,427,600.00	652,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	202,500.00	00.00
210604	Урсгал засвар	2,225,100.00	652,200.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	1,188,800.00	1,380,000.00
210702	Дотоод албан томиллолт	1,188,800.00	1,380,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	20,026,378.00	483,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,001,162.00	83,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	25,216.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20,556,604.50	66,137,413.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,971,118.00	2,354,506.00
210903	Үндсэн хөрөнгийн өлөгдөл, хорөгдол	16,585,486.50	63,782,907.83
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	27,039,126.00	104,958.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	26,904,642.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	26,904,642.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	5,416.00
213402	Урсгал өийг ажиглаганы санхүүжилт сумдад	00.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,416.00

Баянбулаг сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	134,484.00	99,542.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	134,484.00	99,542.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>4,868,821.18</b>	<b>-48,640,970.51</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	72,482,825.11	1,021,994.83
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,021,994.83
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	72,482,825.11	00.00
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-72,482,825.11	-1,021,994.83
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-67,614,003.93</b>	<b>-49,662,965.34</b>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>333,195,042.00</b>	<b>370,516,520.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>333,195,042.00</b>	<b>370,516,520.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,746,900.00	332,339,400.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>35,079,710.00</b>	<b>83,400.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,079,710.00	83,400.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>23,320,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	23,320,400.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,368,432.00</b>	<b>14,773,320.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,368,432.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	14,773,320.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>333,195,042.00</b>	<b>370,516,520.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>333,195,042.00</b>	<b>370,516,520.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>306,155,916.00</b>	<b>370,411,562.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>181,039,100.00</b>	<b>227,968,178.00</b>
210101	Үндсэн цалин	134,004,100.00	168,920,600.00
210102	Нэмэгдэл	33,839,500.00	46,682,110.00
210104	Урамшуулал	13,195,500.00	12,365,468.00

Баянбулаг сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,724,800.00	28,497,300.00
210201	Тэтгэврийн даатгал	15,100,900.00	19,460,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,656,000.00	2,259,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,324,800.00	1,807,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	331,200.00	451,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,311,900.00	4,518,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,640,400.00	20,314,984.00
210301	Гэрэл, цахилгаан	2,790,400.00	3,090,284.00
210302	Түлш, халаалт	15,650,000.00	16,824,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,068,900.00	24,494,890.00
210401	Бичиг хэрэг	450,000.00	1,182,900.00
210402	Тээвэр, шатахуун	17,506,800.00	21,077,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	712,800.00	1,306,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,399,300.00	928,100.00
<b>2105</b>	<b>Нормигивт зардал</b>	26,700,000.00	25,231,604.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,750,000.00	17,442,075.00
210502	Хоол, хүнс	5,000,000.00	5,749,529.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,950,000.00	2,040,000.00
<b>2106</b>	<b>Эд хөгшил, урсгал засварын зардал</b>	5,063,200.00	18,051,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,375,000.00	13,651,000.00
210602	Тавилга	00.00	1,400,000.00
210604	Урсгал засвар	2,688,200.00	3,000,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	1,188,800.00	1,380,000.00
210702	Догоод албан томиллолт	1,188,800.00	1,380,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	24,930,716.00	13,050,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,905,500.00	12,650,600.00
210802	Аудит, багалгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	25,216.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,800,000.00	11,423,006.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,800,000.00	11,423,006.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	27,039,126.00	104,958.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	26,904,642.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	26,904,642.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	5,416.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,416.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	134,484.00	99,542.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	134,484.00	99,542.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын сруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүг	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,097,841.00	69,589,273.93	1,096,981,003.97	00.00	1,358,668,118.90
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,097,841.00	69,589,273.93	1,096,981,003.97	00.00	1,358,668,118.90
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	192,097,841.00	69,589,273.93	1,096,981,003.97	00.00	1,358,668,118.90
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-49,662,965.34	00.00	-49,662,965.34
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	192,097,841.00	69,589,273.93	1,047,318,038.63	00.00	1,309,005,153.56

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	296,746,900.00	296,612,416.00	375,852,000.00	370,328,162.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	296,746,900.00	296,612,416.00	375,852,000.00	370,328,162.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	296,746,900.00	296,612,416.00	375,852,000.00	370,328,162.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,039,100.00	181,039,100.00	227,977,700.00	227,968,178.00
210101	Үндсэн цалин	134,004,100.00	134,004,100.00	168,920,600.00	168,920,600.00
210102	Нэмэгдэл	33,839,500.00	33,839,500.00	46,689,100.00	46,682,110.00
210104	Урамшуулал	13,195,500.00	13,195,500.00	12,368,000.00	12,365,468.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,724,800.00	21,724,800.00	28,497,300.00	28,497,300.00
210201	Тэтгэврийн даатгал	14,572,500.00	14,572,500.00	19,460,100.00	19,460,100.00

Баянбулаг сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	1,788,100.00	1,788,100.00	2,259,300.00	2,259,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,430,500.00	1,430,500.00	1,807,400.00	1,807,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	357,600.00	357,600.00	451,900.00	451,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,576,100.00	3,576,100.00	4,518,600.00	4,518,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,640,400.00	19,640,400.00	20,320,400.00	20,314,984.00
210301	Гэрэл, цахилгаан	2,790,400.00	2,790,400.00	2,490,400.00	3,090,284.00
210302	Түлш, халаалт	15,650,000.00	15,650,000.00	17,430,000.00	16,824,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00	400,000.00	400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,068,900.00	20,068,900.00	28,302,300.00	24,494,890.00
210401	Бичиг хэрэг	450,000.00	450,000.00	1,200,000.00	1,182,900.00
210402	Тээвэр, шагахуун	17,506,800.00	17,506,800.00	23,086,300.00	21,077,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	712,800.00	712,800.00	2,016,000.00	1,306,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөлдөөний устгал, ариутгал	1,399,300.00	1,399,300.00	2,000,000.00	928,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	26,700,000.00	26,700,000.00	26,647,000.00	25,231,604.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,750,000.00	17,750,000.00	18,447,000.00	17,442,075.00
210502	Хоол, хүнс	5,000,000.00	5,000,000.00	5,750,000.00	5,749,529.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,950,000.00	3,950,000.00	2,450,000.00	2,040,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,063,200.00	5,063,200.00	18,085,000.00	18,051,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	2,375,000.00	2,375,000.00	13,685,000.00	13,651,000.00
210602	Тавилга	0	0	1,400,000.00	1,400,000.00
210604	Урсгал засвар	2,688,200.00	2,688,200.00	3,000,000.00	3,000,000.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	1,200,000.00	1,188,800.00	1,620,000.00	1,380,000.00
210702	Дотоод албан томилголт	1,200,000.00	1,188,800.00	1,620,000.00	1,380,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,510,500.00	15,387,216.00	12,967,200.00	12,967,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,362,000.00	15,362,000.00	12,567,200.00	12,567,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	0	400,000.00	400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,500.00	25,216.00	00.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,800,000.00	5,800,000.00	11,435,100.00	11,423,006.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,800,000.00	5,800,000.00	11,435,100.00	11,423,006.00

Баянбулаг сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	296,746,900.00	296,612,416.00	375,852,000.00	370,328,162.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	296,746,900.00	296,612,416.00	335,139,400.00	332,239,858.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,746,900.00	296,612,416.00	335,139,400.00	332,239,858.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00	23,320,400.00	23,314,984.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	23,320,400.00	23,314,984.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	00.00	17,392,200.00	14,773,320.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00	17,392,200.00	14,773,320.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	24	24	24	24
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13	14	14
620003	Үйлчлэх ажилтан	6	6	6	6
620004	Гэрээт ажилтан	4	4	3	3
640001	Улсын эмнэлгээр хэв- тэн эмчлүүлэгсэд	295	295	295	295
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	4,100	4,100	4,298	4,298
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	24	24	24	24
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	00.00	00.00	16	16
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	6	5	5
650010	Гэрээт ажилтан	4	4	3	3

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР  Д.ЦЭЦЭГМАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН: ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЦЭЭНЯМ

Б.МӨНХБАТ

